

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ЭБАТ-НЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2024 онд Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 3 зорилт 20 ажилтай нэгдсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхний хагас жилийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 07-нд хүргүүлэхээр хэрэгжилтийг хангаад байна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас ХАСХОМ-ын 2023 оны мэдүүлгийг шинэчлэн гаргах 8 албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлгийг гаргуулж, баталгаажуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлагын тасагт 2024 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 3/62 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр байгууллагын удирдлага болон албан хаагчдыг АТГ болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 13 албан хаагчийг хамруулсан.



Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудасанд 3 сошиал сувгуудад 5, дотоод сүлжээнд 3-ыг 7 хоног тус тус байршуулж, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын пэйж хуудас болон албан хаагчид тус бүр өөрийн фэйсбүүк, твиттерт байршуулж иргэд олон нийтэд түгээж ажилласан.

Ажлын байранд авлигын эсрэг мэдээллийн самбар 1, авлигын эсрэг зурагт хуудсыг 6, албан хаагчдын өрөөний хаалга, компьютер зэрэгт авлигын эсрэг сурталчилгааны наалт 10-ыг тус тус байршуулж мэдээллээр хангаж ажиллаа.




Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагаас зохион байгуулах үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байх зорилгоор Авлигын эсрэг "МЭДЬЕ, НЭГДЬЕ" аянд нэгдэж Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем [erp.ulaanbaatar.mn](http://erp.ulaanbaatar.mn) болон байгууллагын цахим хуудсанд

байгууллагын албан хаагчдыг оролцуулсан 1 минутын бичлэгийн сурталчилгааг хийж орууллаа.



Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийг үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр “Авлигын эсрэг нэгдье” уриалгын дор зохион байгуулж авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар Нийслэлийн нутгийн захиргааны 62 байгууллагын 825 албан хаагч, есөн дүүргийн хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжийн нийт 451 байгууллагын 6615 ажилтан албан хаагч болон нийт 30 мянга гаруй ард иргэдэд мэдээ мэдээлэл, сурталчилгааг явуулж ажилласан.



2024 оны эхний хагас жилийн байдлаар манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ямар нэгэн гомдол, зөрчил, маргаан бүртгэгдээгүй болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,  
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



М.ЦОГЗОЛМАА

9024010069 CTC4588 9077448